

тэнд орших уугуул нутгийн улаан арьстан нарыг индиан нар (энэтхэгчүүд) гэж нэрлэсэн нь тэр гэдэг биз дээ. Энэ мэтээс үзсэн ч Чингис хаан, Монголын байлдан дагуулал, Монголын феодалын эзэнт гүрний сайн саармаг нөлөө, харгис, дэвшилт үр дагавар нь гагцхүү эзлэгдсэн улс орон, зөвхөн тухайн цаг үеэр хязгаарлагдаагүй, нэн давуу орон, цагийг эзэмдсэн их үйл явдал байсан ажээ.

Ертөнцийн улс түмний түүх, Ази, Европын орнуудын амьдрал, хөгжилд бүхэл бүтэн үеийг эзэлж, ул мөрөө үлдээсэн тийм үйлийг хэрэв тэр нь дан харгис шинжтэй байсан бол монгол шиг цөөн тооны хэдэн нүүдэлчид, Чингис мэтийн ганц эр хэдий сүрхий байлаа ч гэсэн бүтээж хүч хүрэхгүй байсан бизээ. Тийм дуулиантай үйл нэгэнт бүтсэн болохоор түүнийг заавал харгис бурангуй байгаад бүтэв гэж үзэхэд бэрх. Чингис хаан, Монголын байлдан дагуулал, Монголын феодалын эзэнт гүрэн бий болж, нэлээд удал оршин тогтносон нь огт санамсаргүй хэрэг биш ч байж магад. Монголын феодалын эзэнт гүрэн шиг их гүрэн байгуулагдах нь зайлшгүй шаардлагатай зүйл биш байлаа ч гэсэн түүний бий болох бодит боломж нөхцөл бүрдээд байсны улмаас Чингис хаан, түүний үр ач нарын байлдан дагуулал амжилт олсон хэрэг. Түүнийг хэрэгжүүлэхэд Чингисийн төрийн бодлого, цэрэг дайны стратеги, тактик, хүннү сяньби нарын үеэс эхлэн Монгол нутаг, Төв Азид оршин амьдарч байсан нүүдэлчин улс түмнүүдийн цэрэг-улс төрийн уламжлал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байж болно. Хэрэв тийм уламжлал байгаагүйсэн бол Монгол гүрэн шиг их эзэнт гүрэн, Монголын байлдан дагуулал шиг нүсэр аян дайн, Чингис шиг байлдан дагуулагч гарч ирэх байсан, эсэх нь хараахан тодорхойгүй.

Чингис хаан зөвхөн Монголын төдийгүй, нийт Төв Азийн нүүдэлчин улс түмний цэрэг-улс төр, дэлхийн нийтийн түүхийн нэрд гарсан томоохон зүтгэлтэн мөн. Гэвч түүний хийсэн аян дайн, Монголын феодалын байл дан дагууллыг үнэхээр зарим талын дэвшилттэй байлаа ч гэсэн бусдыг түрэмгийлж, цус урсган, эвдэж сүйдэлснийх нь хувьд бид сайшааж бахархдаггүй юм.

**ХЯТАДТАЙ ХАРИЛЦААГАА
САЙЖРУУЛАХ ТАЛААР МАХН,
АРДЫН ЗАСГИЙН ГАЗРААС
ГАРГАСАН ХҮЧИН ЧАРМАЙЛТ
(1921—1925 он)**

Түүхийн ухааны дэд эрдэмтэн
Р. ОТГОН

МАХН үүсч байгуулагдах үеэсээ эхлэн хятадын их ард түмэнтэй эв найрамдалтай аж төрөх гэсэн монголын ард түмний чин эрмэлзлэлийг илэрхийлж байв. Тухайлбал Монгол Ардын Нам 1921 оны гуравдугаар сарын 25-нд гаргасан уриалах бичигтээ «Дэлхийн империализмд боолчлогдон дарлагдсан бүх дэлхийн ба Ази тивийн эрх чөлөөгүй, колонийн ард түмэн, хөдөлмөрчин ард түмний эрх ашиг, эв санал нэг байдаг хий-

гээд мөн дотоод гадаадын харгисуудад нэг адил дарлагдан мөлжигдөж байгаа хятад, монголын ард түмний эрх ашиг гүнээ ижил тул Монголд цэрэг илгээхээ нэн даруй зогсоохыг Монгол Ардын Намын Төв Хороо, Монголын бүх хөдөлмөрчид, сэхээтний өмнөөс Бээжингийн засгийн га зарт хатуу шаардахын хамт, хятадын бүх ард түмэн, түүний хамгийн сайн санаат тэргүүний хэсэгт чин сэтгэлийн нөхөрсөг мэндчилгээ дэвшүүлж, манай шаардлагыг угтан авч засгийнхаа газарт ёс суртхууны болон бусад даралт шахалт, нөлөө үзүүлэхийг уриална»¹ гэжээ. Энэ үед империалист гүрнүүдийн өөгшүүлгээр Умарт Хятадын эрх баригчид Монголыг байлдан эзэлж Хятадад нэгтгэх аюул тулгарч байсантай холбог дуулан хятадын хөдөлмөрчин ард түмэн, түүний тэргүүний дэвшилт хэсэгт хандаж дээрх уриалгыг гаргажээ.

Октябрийн аугаа их социалист хувьсгалын шууд нөлөөгөөр. МАХН ын удирдлагаар 1921 онд Монгол оронд империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгал ялалтад хүрч, монголын ард түмэн эрх чөлөө. тусгаар тогтнолоо байлдан олсон билээ.

Ардын засгийн газраас 1921 оны есдүгээр сарын 14-нд дэлхийн олон улсад хандаж гаргасан мэдэгдэх бичигт Монгол улс тусгаар тогтносон тухай зарлаж, тэдэнтэй найрсаг харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм. Манай ардын засгийн газар Дундад улстай өшөө хорсголыг агуулан, байлдан дайтах хүсэлгүй байгааг, нөгөө талаар Хятадын сюзеренитетийг дахин хүлээж хэрхэвч чадахгүй, гагцхүү одоогийн байгуулсан ардын эрхт засаг л улс орноо удирдах болно гэдгийг ёс төртэй мэдэгдэж, Дундад улстай найрсаг харилцаатай байж улмаар худалдаа арилжааг тэгш эрхийн үндсэн дээр явуулах эрмэлзэлтэйгээ нотолсон байна.²

Хөрөнгөтөн орнууд манай улсын найрсаг харилцаа тогтоох тухай саналыг үл хайхран, Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүйгээр барахгүй ардын засгийг түлхэн унагаах бодлого явуулж байв. Харин ганцхан Зөвлөлт Орос Улс шинэ залуу Монгол улстай найрамдалт харилцаа тогтоон хөгжүүлэх нь хоёр орны ард түмний болон социалист хувьсгалын эрх ашигт бүрэн нийцнэ гэж үзсэн учир 1921 оны арван нэг дүгээр сарын таванд ардын эрхт Монгол улс, Зөвлөлт Орос улсын хооронд хамтран ажиллаж, харилцан туслах зарчим дээр үндэслэсэн хэлэлцээр байгуулагдсан юм.

Зөвлөлт Орос Улс энэхүү хэлэлцээрээр манай улсын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн нь олон улсын талбарт Монгол улсын халдашгүй дархан эрхийг улам бататгах улс төрийн чухал дэмжлэг болов, Ардын хувьсгал ялсны дараа манай орны гадаад дотоод байдал туйлын хүнд байсан нөхцөлд ардын хувьсгалыг гадаад дотоодын дайсны өнгөлзлөгөөс хамгаалж, БНМАУ-ын тусгаар тогтносон бүрэн эрхт байдлыг хангахад энэхүү хэлэлцээр асар их үүрэг гүйцэтгэсэн юм.

Монгол оронд ардын хувьсгал ялсны дараа Хятадын умарт хэсгийг захирч байсан милитарист Чжан Цзолинь Монголыг эзлэн авах төлөвлөгөө зохиож, цэргээ Монголын зүүн хилд ойртуулан довтолохоор идэвхийлэн бэлтгэж байсан боловч Зөвлөлтийн Улаан армийн ангиуд Монголд байсан, хятадын милитарист бүлгүүд хоорондоо тасралтгүй тэмцэлдэж, империализмыг эсэргүүцсэн Хятадын ард түмний хөдөлгөөн хүчтэй өрнөн Монголын тусгаар тогтнолыг Хятадын хувьсгалч дэвшилт хүчин дэмжиж байсны ачаар тэрээр Монголд довтолж чадаагүй билээ.

Ардын хувьсгалын ялалтын үр дүнд Монгол улс тусгаар тогтнолоо шинэ үндсэн дээр сэргээснээс хойш хятадын харгис хүчин манай орныг түрэмгийлэн эзэлж Хятадын хэсэг болгох бодлого явуулж байсан бол

хятадын хувьсгалт дэвшилт хүчин Монголын тусгаар тогтнолыг дэмжиж байжээ. Жишээ нь: Хятадын Коммунист намын долоо хоног тутмын сонин «Сяндао жибао» 1922 оны есдүгээр сарын 27-ны дугаартаа «Монголын талаархи асуудалд хэрхэн хандвал зохих вэ?» гэсэн өгүүлэл нийтэлжээ. Олон улсын империализм ба дотоодын милитаристуудын эрхшээлд буй Хятад орон, Монголыг Хятадын бүрэлдэхүүнд ороод өөрийгөө гашуун хувь заяа эдлэхгүй байх болно хэмээн батлах үндэс байна уу? гэж асуулт тавиад мөнхүү сонинд хариулж бичихдээ: «Монголыг Хятадын захиргаанд оруулна гэдэг бол милитаристуудын газар болон империалистуудын колонийг өргөтгөнө гэсэн үг... Бид ийм явдал хэрхэвч гаргуулахгүй. Харин Хятад орон болон түүний ард түмэн монголын ард түмний байлдан олсон тэр зүйлийг олж авахын төлөө тууштай тэмцэх болно. Империалистууд болон милитаристууд Монголыг байлдан дагуулах тухай хашгирч байгаа бол бидний хөдөлмөрчид Монголын тусгаар тогтнолыг дэмжиж, монголын ард түмний эрх чөлөөг бэхжүүлэхийн төлөө тэмцэх болно ... Хятадын дарлагдсан ард түмэн монголын ард түмэнд хандахдаа Хятад оронд та нарын нэгэн адилаар бидний үзэн ядагч дарлагчдаас гадна, та нарын анд нөхөд олон бий гэдгийг мэдэгдэж байна. Бидний нийтийн дайсныг тонилгохын тулд ах дүүгийн найрамдлаа улам бэхжүүлэе» гэж бичсэн байна.

Хятадын ард түмнээс гадаад дотоодын дайсны эсрэг тэмцэлдээ ЗХУ ын тал бүрийн тусламжийг авахад шинэ тулгар хувьсгалт Монгол улс чухал үүрэг гүйцэтгэж байв. Энэхүү байдлыг хятадын хувьсгалчид, интернационалч үзэлтэн нар ойлгох Монголын тусгаар тогтнол болон ЗХУ-тай түүний тогтоосон найрсаг харилцааны мөн чанарыг үнэлж, империалист харгис хүчнээс гаргаж байсан элдэв гүтгэлгийг няцааж байв. Хятадын их хувьсгалч Сунь Ятсен: «Монгол ард улсад Орос улс их нөлөө үзүүлж байна гэлцэх юм. Тэнд орос улс нөлөөлж байгаа нь харин сайн хэрэг. Монгол орон хятадын милитаристууд, Унгерн зэргээс болж хичнээн их хэлмэгдсэнийг бид мэднэ. Монгол эрх чөлөөтэй орон байг»³ гэж хэлж байжээ. Сунь Ятсен 1923 оны нэгдүгээр сард Зөвлөлт Орос Улсын төлөөлөгч А. А. Иофкетэй уулзаж ярилцахдаа «...Оросын цэрэг, Монголоос гарсны дараа Бээжингийн засгийн газар орос улсын эсрэг чиглэсэн цагаан гвардынхны өдөөн хатгагч дайсагнагч ажиллагаа дахин сэргэх явдлыг зогсоох бодолгүй байгаа одоо үед оросын цэргийг нэн даруй гаргахын чухлыг болон тэр нь хятадын үнэнхүү эрх ашигт нийцэж байгааг би олж харахгүй байна»⁴ гэж мөн мэдэгдэж байжээ. Энэ бүхэн нь бодит байдлыг зөв үнэлсэн ухаалаг хандлага байлаа.

Монголын ардын засгийн газар, Хятадын засгийн газартай шууд харилцах замаар харилцаагаа сайжруулах гэж хэдэн удаа оролдож байгаад бүтэхгүй болохоор нь жуучилж өгөхийг Зөвлөлт засгийн газарт 1921 оны есдүгээр сарын 10-нд хүсчээ. Зөвлөлийн засагт Орос Улсын Гадаад хэргийг эрхлэх ардын комиссариатад Монголын ардын засгийн газрын ерөнхий сайд бөгөөд гадаад хэргийн яамны тэргүүн сайдаас явуулсан нотод «...Одоо Монгол улсын олон түмэн ард өөртөө эзэрхэх эрхийг эгүүлэн авахад гадаадын харгисыг байлдан сөнөөж, орон нутгаа цэвэрлэн арилгаж, баатар зоригтой ардын цэргийн сүрийг үзүүлэн тусгаар тогтнох бүрэн эрхтэй улс болох эрх чадлаа хэдийгээр дэлхий дахины олон улсын нүдний өмнө илрүүлсэн боловч Монгол, Хятадын хооронд найрамдлыг байгуулан хоёр улсын албан хэргийг харилцан нэвтрүүлэх явдал одоо хүртэл илрээгүй бүхий нь гэмшилтэйгээр үл барам, ийнхүү шалтгаанаас болж манай монгол газар бүхий гадаад дотоод хүчнийг энх

түвшний улиралд хандуулан Монгол, Дундад, Оросын гурван этгээдийн ардад нэгэн адил ашиг тус бүхий олон улстай худалдаа нэвтрүүлэх аливаа хэргийг журамлан ёсоор явуулахад бэрхтэй болсон явдлыг хамтад илэрхийлэн гаргахад Дундад улсын түмэн ард ба тэдний засгийн газраас монголын ард түмнийг өөрийн мэдэлд эзэрхэн хурааж, манай улсын дэвсгэр газрыг түрэмгийлэн эзлэх санааг хэрхэвч агуулахгүй гэж итгэж, бас эрхэм комиссар таны сануулсныг хүндэтгэн хөндлөн этгээд болон жуучлан туслах явдлыг зөвшөөрөн хүлээх бизээ гэж итгэж Үүний тулд эрхэм танаас яаравчлан хариу ирүүлэхийг эрмэлзэн байгааг илэрхийлэн явуулав»⁵ гэжээ. Зөвлөлт Орос улсын засгийн газар монголын ард түмний энэ эрмэлзлэлийг дэмжин хүлээн авч 1921 оны есдүгээр сарын 14-нд ирүүлсэн хариу нотдоо: «... Оросын засгийн газраас Монголын хувьсгалт засгийн газрын Хятадтай найрамдал, аливаа хэргийн учир харилцан нэвтрэлцэхтэй хамт тус улсын язгуурын чөлөө эрхийг батлах гэснийг машид зөвшөөрөөд энэхүү хэргийг дав дуваар бүрэн бүтэн болгохыг итгэмжлэн, манай Орос засгийн газраас Хятадын засгийн газарт шууд нэвтрүүлснээс гадна Хятад улстай харилцан нэвтрэлцэж бүхий Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын төлөөлөгчөөр уламжлан энэхүү хэргийн учир хэлэлцээ “эхлэхийг Хятадын засгийн газарт сануулсан болой. Одоо ойрноос Орос засгийн газар Хятадтай худалдааны гэрээ байгуулахын тулд тусгай төлөөлөгчийг явуулж үргэлжид харилцан нэвтрэлцэхийг эрмэлзсээр буй бөгөөд Монголын хувьсгалт ардын засгийн газрын 1921 оны есдүгээр сарын 10-ны өдрийн бичигт манай засгийн газрыг Монгол, Хятад хоёрын хооронд жуучилна уу гэснийг Оросын засгийн газар баясан хүлээв. Бас Монголын ард ба засгийн газар, Хятадын бүгд найрамдах улстай эвдрэлийг цээрлэн энэхүү жуучлах явдлыг Хятадын засгийн газраас сайшаан хүлээнэ гэж манай засгийн газар итгэмжлэнэ»⁶ гэжээ.

Монголын ардын засгийн газар Хятад улстай найрамдалт харилцаатай болох гэсэн оролдлогоо үргэлжлүүлсээр байв. Манай засгийн газар Хятад болон бусад гадаад орны пүүсүүдтэй харилцан ашигтай нөхцөлд бараа таваар солилцож болохыг өөрийн худалдааны байгууллагуудад зөвшөөрснөөс гадна Алс Дорнодын энх тайван, аюулгүй байдлын эрх ашиг, мөн хоёр орны ашиг сонирхлын үүднээс Монголд буй болсон бодит нөхцөл байдлыг Бээжингийн засгийн газраар хүлээлгэн зөвшөөрүүлэхийг оролдсоор байжээ. Бээжингийн засгийн газар болон Хятадын газрын эзэд, хөрөнгөтөн, янз бүрийн милитарист бүлэглэлүүд энэ талаар ямар нэгэн нааштай алхам хийхийг хүсээгүйгээр барахгүй, харин Монгол, Хятадын хоорондын харилцааг яаж ийгээд хүндрүүлэхийг оролдож байжээ. Бээжингийн засгийн газар монголын асуудлыг Хятадын дотоод асуудал мэтээр шалтаглан Зөвлөлт Орос Улсын жуучлахыг татгалзаж байв.

Зөвлөлт Холбоот Улсын хүчин чадал, олон улсын нэр хүнд өсөн нэмэгдсэн, Хятадад хувьсгалт хөдөлгөөн өрнөж иргэний дайн 1924 —1927 онд болсны ач нөлөөгөөр Бээжингийн засгийн газар Монгол руу илэрхий довтолгоон хийх бололцоогүй байсан юм. Тийм учраас Бээжингийн засгийн газар заншиж дадсан хуучин аргаа хэрэглэж Монголын феодалуудыг өөрийн талд татах, мөн дипломат замаар зорьсондоо хүрэх гэж эрмэлзэж байжээ. Монголд ардын хувьсгал ялсан үеэс эхлэн Бээжингийн засгийн газар Монголоос Зөвлөлтийн цэргийг гаргах, Зөвлөлт-Монголын 1921 оны арваннэгдүгээр сарын 5-ны найрамдлын барилдлагаг байгуулах тухай хэлэлцээрийг дахин хянаж үзэх тухай асуудлыг Зөвлөлт Оросын төлөө-

лөгчидтэй хийх хэлэлцээний болзлын нэг зүйл болгон тавьж байв. «Зөвлөлт Оросын гадаад бодлого» хэмээх 1924 онд Лондонд хэвлэгдсэн Алфред Деннисийн номд Хятадын засгийн газар дээр өгүүлсэн хэлэлцээр байгуулсан тухай асуудлаар 1922 оны тавдугаар сарын 1-нд Зөвлөлтийн төлөөлөгчид эсэргүүцэл тавьж Гадаад Монгол бол Хятадын газар нутаг гэж нотлохыг оролдож байсан тухай өгүүлсэн байна.

1920 оны өвлөөс оросын цагаантан Барон Унгерний цэрэг Монголын зүүн хойд хязгаараар цөмрөн орж ирсэн бөгөөд 1921 оны хоёрдугаар сарын 3-нд нийслэл хүрээг эзэлжээ. Энэ үед японы империализм, оросын цагаантны толгойлогч Атман Семенов, зүүн хойт Хятадын захирагч генерал Жан Цзолин нар Барон Унгернийг дэмжиж, Монгол орныг Зөвлөлт Орос улсын эсрэг явуулах дайны талбар болгохыг эрмэлзэж байв. Ийм нөхцөлд Монгол дахь оросын цагаантныг устгах явдал ЗХУ-ын аюулгүй байдлыг хангах хойшлуулшгүй арга хэмжээний нэг нь болсон юм. Монголын талаар ямар ч түрэмгий санаа агуулаагүй Зөвлөлт засгийн газар Монголд орогносон цагаантны дээрэмчин отрядуудын эсрэг хамтран тэмцэх тухай Хятадын засгийн газарт удаа дараа санал тавьж байжээ. Тухайлбал 1920 оны арваннэгдүгээр сарын 10, 27-ны өдрүүдэд Зөвлөлт Орос Улсын Гадаад хэргийн ардын комиссар Г. В. Чичерин Хятадын засгийн газарт Монголд бүгсэн оросын цагаантныг хамтарсан хүчээр устгах тухай болон уг ажиллагааг дуусмагц тэндээс цэргээ татах тухай санал тавьж нот илгээж байсан боловч Хятадын талаас хариу өгөөгүй ажээ. Иймд Монголын засгийн газрын хүсэлтээр Зөвлөлт Орос Улс цэргийн зарим ангиа Монголд оруулж Монголын ардын хувьсгалт цэрэгтэй хамтран цагаантны отрядуудыг бут цохиж, цэргээ түр үлдээн 1921 онд Монголтой хэлэлцээр байгуулсан нь Зөвлөлт Орос улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ болно гэдгийг Хятадын засгийн газарт Зөвлөлт засгийн газар мэдэгдэж үйл ажиллагаагаараа нотолсон юм.

Үүний хамт Зөвлөлт Орос Улс нь ажилчин тариачны улсын хувьд монгол, Хятадын ард түмний аль алинд нь империалист дарлалаас чөлөөлөгдөн эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авахыг нь дэмжин монгол, Хятадын хувьсгалт хүчнүүдэд тусламж дэмжлэг үзүүлсээр байв.

Монгол, Хятадын ард түмний хооронд харилцан ойлгох, бие биесээ дэмжих эв нэгдлийн үзэл санаа бүрэлдэн тогтоход МАХН-ын интернационалч үйл ажиллагаа ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. 1922 оны эхээр Москва, Петроград хотноо хуралдсан Алс Дорнодын ард түмний хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хуралд Монгол Ардын Нам, Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн төлөөлөгчид оролцохдоо хятадын хөдөлмөрчдийн төлөөлөгчидтэй уулзаж хоёр орны хувьсгалт хөдөлгөөний эв нэгдлийн талаар ярилцаж байжээ. Энэ хурал дээр монголын төлөөлөгч С. Буяннэмэх хэлсэн үгэндээ монгол, Хятадын ард түмний эв найрамдлыг 1921 оны гуравдугаар сард МАН-аас гаргасан уриалах бичигт тунхагласан зарчмын үндсэн дээр цаашид хөгжүүлэх санал эрмэлзэлтэй байгаа болон тэрхүү харилцааны сайн төлөвд итгэж байгаагаа илэрхийлжээ.⁷

Тус их хуралд Коментерний Гүйцэтгэх Хорооноос оруулсан илтгэлд Монгол, Хятадын харилцааны асуудлыг тусгайлан тэмдэглэсэн байна. Монголыг Хятадад нэгтгэх талаар империалист гүрнүүдийн баримталж буй санаархлыг энэ илтгэлд шүүмжлэн эсэргүүцэхийн хамт Өмнөд Хятадын хувьсгалт хүчинд хандаж уг асуудлын талаар үхширмэл байр сууринаас биш, харин Монгол улсын тусгаар тогтносон бодит байдлыг харгалзах үүднээс ажиллахыг уриалжээ.⁸

Хятадын милитарист бүлэглэлүүдийн зүгээс Монгол орны тусгаар тогтнолд байнга заналхийлж байсан нөхцөлд хятадын хувьсгалт хүчинтэй харилцаагаа өргөтгөх чиглэлийг МАХН баримталсан нь үндэсний болон интернационалч эрх ашигт гүнээ нийцсэн зөв алхам байв. Хятадын дэвшилт хүчинтэй хэлхээ холбоо тогтоохоор МАХН-ын Төв Хорооны дарга 1923 оны эцэс 1924 оны эхээр Бээжин, Кантонд очиж хятадын удирдагчид болон хувьсгалт хүчний удирдах хүмүүстэй уулзжээ. Бээжингийн эрх баригчид МАХН-ын төлөөлөгчид Монгол бол «Улаан Орос» эзлэн авсан Хятадын муж» гэж итгүүлэхийг оролдсон байна. Үүнтэй холбогдуулан эрс эсэргүүцэл илэрхийлж «Монгол бол тусгаар тогтносон улс бөгөөд өөрийн газар нутагт хятадын цэргийг оруулах явдлыг хэрхэвч гаргуулахгүй»⁹ гэж МАХН-ын Төв Хорооны дарга мэдэгдэл хийжээ. МАХН-ын Төв Хорооны дарга Кантонд Гоминдан намын удирдагч Сунь Ятсентэй уулзахад, тэрээр «Манай хоёр нам хойт, урд талаас цохилт өгч Хятадын харгисуудыг устган өөрсдийн ард түмэнд эрх чөлөөг авчрах ёстой»¹⁰ гэжээ.

Сунь Ятсений удирдсан хувьсгалт гоминдан монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийг талархан дэмжиж байжээ. 1925 оны нэгдүгээр сард хуралдсан Гоминданы анхдугаар их хурлын тунхагт монголчуудад тусгаар тогтнох эрх олгохыг шаардсан байна.

1924 онд хуралдсан МАХН-ын II их хурал «Аливаа бүх хувьсгалчдын зорилго бол Хятад орон, Хятадын хөдөлмөрчдийг эдгээр араатны (хятадын милитаристуудын Р. О) эрх мэдлээс ангижруулж бүх хүн төрөлхтнийг чөлөөлөхийн төлөө аугаа их тэмцэлд манай жинхэнэ хань холбоотон болгоход оршино»¹¹ гэж заасныг үйл ажиллагаандаа МАХН тууштай баримталсан юм. Намын Төв Хорооны 1925 оны гуравдугаар сарын бүгд хурлаас сайшаасан намын Програмын төсөлд хятадын ард түмний эрх чөлөөний тэмцэл, Хятадын Коммунист нам ба Сунь Ятсений байгуулсан Гоминданы хувьсгалт үйл ажиллагаатай МАХН эв санааны нэгдэлтэй байгааг илэрхийлэн «Хятадын ард түмэн дэлхийн эзэрхэг түрэмгийчүүд ба тэдэнд биеэ худалдсан хятадын хөрөнгөтний ангийг эсэргүүцэж, эрх чөлөөгөө эрмэлзэж тэмцэхэд монголын жинхэнэ ард түмэн халуун сэтгэлээр тусламж үзүүлнэ»¹² гэж дурджээ.

А. Амар тэргүүтэй МАХН-ын албан бус төлөөлөгчид Хятадад 1925 оны дөрөв, тавдугаар сард очиж Сунь Ятсений Кантоны хувьсгалт засгийн газрын талд бат зогсож байсан генерал Фын Юйсянтай хэлэлцээ хийжээ. МАХН-ын төлөөлөгчид Монголд хятадын цэргийг оруулах тухай Фын Юйсяны саналыг эрс татгалзаж, харин түүнээс хойт Хятадын милитаристуудтай явуулах тэмцэлд нь бүх талын дэмжлэг үзүүлэхээр тохиролцсон байна.¹³ Хувьсгалт гоминдантай хэлэлцээ хийлгэхээр 1925 оны наймдугаар сард МАХН-ын төлөөлөгчөөр Ц. Гүрсэдийг Бээжинд явуулжээ. Гоминдан болон түүнтэй хамтран ажиллаж байсан Хятадын Коммунист намын удирдах зүтгэлтнүүдтэй МАХН-ын төлөөлөгч уулзаж ярилцах үед дөрвөн асуудлаар зарчмын тохиролцоонд хүрсэн юм. Энэ нь Монголын тусгаар тогтнох эрхийг гоминдан хүлээн зөвшөөрч, хоёр намын хамтын ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон байна. «Гадаад Монгол аль хэзээний тусгаар тогтносон улс болсон. Иймд Монгол тусгаар тогтносон улс болоход гоминданы зүгээс татгалзах зүйлгүй»¹⁴ гэж гоминданы удирдагчид МАХН-ын төлөөлөгч Ц. Гүрсэдэд мэдэгджээ.

Хятадын Коммунист намын нэрт зүтгэлтэн, тууштай интернационалч Ли Дажао БНМАУ-ын тусгаар тогтнолыг бүрэн дэмжиж байв. Ли Дажао манай намын төлөөлөгчидтэй уулзахдаа «Бид Монголыг бүрэн эрх-

тэй, биеэ даасан улс хэмээн хүлээн зөвшөөрөхийг хүсч байна. Учир нь Монголчууд Хятадаас тусгаарлаад эрх чөлөөгөө хамгаалж чадсан төдийгүй империализмын эсрэг тэмцэлд хятад хүмүүс бидэнд, дэлхийн хувьсгалт хөдөлгөөнд их тус хүргэж байна»¹⁵ гэж хэлжээ.

1925 оны аравдугаар сарын 19-нд МАХН-ын төлөөлөгч Бээжинд очиж Хятадын ерөнхийлөгч Дуань Цижунтай уулзахад тэрээр ЗХУ-д ардчилал байхгүй мэтээр гүтгэн ЗХУ-ын эсрэг хандуулахыг оролдож байжээ. Үүний хариуд МАХН-ын төлөөлөгч «Монголчууд өөрийн улсын тусгаар тогтнолыг тууштай хамгаалж байна. Монголд нэг ч хүн, нэг ч морь үлдээгүй нөхцөлд л тусгаар тогтнолоосоо татгалзана. Монгол эрх чөлөөтэй, гадны ямар нэгэн оролцоо, ивээлийг хүлээхгүй» гэжээ. Дуань Цижун Монгол Хятадын мужаар үлдээд өөрийн хэрэгт бүрэн автономит байж чадна гэж амлахад нь «Монголын ард түмэн өөрийн тусгаар тогтнолыг тууштай хамгаалж, хятадуудын зүгээс хийх шинэ өнгөлзлөгийг эрс шийдвэртэй няцаах болно»¹⁶ гэж МАХН-ын төлөөлөгч хариулжээ.

Монголын ард түмний тусгаар тогтнолоо бэхжүүлэхийн төлөө явуулж байсан тэмцлийг хятадын дэвшилт хүчин, юуны өмнө коммунист интернационалчид тууштай дэмжиж байв. Монгол, Хятадын хувьсгалт дэвшилт хүчин харилцан бие биеэ дэмжиж байсан нь Хятадын милитаристуудын зүгээс БНМАУ-ын тусгаар тогтнолд өнгөлзөж байсан хүнд үед манай улсын тусгаар тогтнол, олон улсын байр суурь бэхжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

МАХН, ардын засгийн газар хятадын хувьсгалыг зүйл бүрээр дэмжих бодлого баримтлахдаа зөвхөн улс төр, ёс суртахууны дэмжлэг үзүүлээд зогсоогүй, өөрийн хир чадлаар эд материалын тусламж үзүүлж байв. Империализмын эсрэг Шанхайд болсон хөдөлмөрчдийн жагсаалыг английн цэрэг буудахад хэлмэгдсэн хятадын ажилчдад мөнгөн тусламж үзүүлэх тухай МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид 1925 оны долдугаар сарын 7-нд тогтоол гарган хэрэгжүүлжээ. Мөн оны аравдугаар сарын 19 ний МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн шийдвэрээр хятадын үндэсний хувьсгалт армийн хэрэгцээнд зориулан зэвсэг тээхэд автомашин болон бусад хөсгөөр хангахыг Аж ахуйн яаманд үүрэг болгожээ.

МАХН, ардын засгийн газраас ардын хувьсгалын анхны жилүүдэд Хятадтай харилцаагаа сайжруулах талаар гаргасан их хүч чармайлтын үр дүнд хятадын дэвшилт хүчин манай улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, БНМАУ, Хятад улсын харилцаа сайжрах хандлагатай болжээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. МАХН ардын хувьсгалын ялалтын төлөө тэмцэлд (Баримт бичгүүд) УБ. 1971. 87—89-р тал
2. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. I боть, УБ., 1964, 7-8-р тал
3. Старицина. К вопросу о советско-монгольских отношениях. (Труды Московского Института Востоковедения) сб. 5.1947, с. 29
4. М. С. Капица, В. И. Иваненко. Тэмцлээр гагнагдсан найрамдал: УБ, 1966, 42-р тал
5. Ардын засгаас 1921—1924 онд авсан хувьсгалт арга хэмжээнүүд УБ 1954. 197-198-р тал
6. «Урна» сонин, 1921 оны 9-р сарын 21
7. МАХН, ЗХУКН социализмын төлөө ах дүү ёсоор хамтран тэмцсэн түүхэн туршлага. УБ., 1971, 293-р тал
8. «Новая Монголия» УБ. 1925. 11—12-р тал
9. Намын Төв Архив ф. 1. 0. 6, е. х 122. 2--3-р тал

10. НТА. Ф. 1, 0.7, е. х. 122. 2-3-р тал
11. НТА. Ф-1, Д-32, ХН-4, 5-р тал
12. МАХ-ын их, бага хурал, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр 1-р дэвтэр. УБ., 1956. 104-р тал
13. НТА. Ф. 1, 0.2, е. х. 139, 88-89-р тал
14. НТА. Ф. 1, 0.2, е. х. 176, 7-8-р тал
15. Роль и значение помощи международного коммунистического движения в становлении и развитии МНРП. М., 1978, 206-р тал
16. НТА. Ф. 1, 0.2. е. х. 176, 104-р тал